



Бурхан бол Мөнх Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

Мөн чанар: Бурхан бол Мөнх

Attribute: God Is Eternal

Тодорхойлолт: Эхлэл ба төгсгөл үгүй; бүх цаг үед оршигч; мөнхийн мөнх Нэгэн.

Эшлэл(үүд):

- **Гэтлэл 3:14-15** Бурхан, Мосед – Би бол “Би байгаа юм” гэв. Тэгээд Тэр – Израилийн хөвгүүдэд чи “Би байгаа” намайг та нар уруу илгээв” гэж хэл гэв. Цааш нь Бурхан, Мосед – Израилийн хөвгүүдэд чи “Эцэг өвгөдийн чинь Бурхан, Абрахамын Бурхан, Исакийн Бурхан, Иаковын Бурхан Эзэн намайг та нар уруу илгээв” гэж хэл. Энэ нь мөнхөд Миний нэр бөгөөд үеийн үед Миний дурсгалт нэр юм.
- **Дуулал 90:1-2** Аяа Эзэн, Та үеийн үед бидний Орших газар байсан билээ. Уулс бий болохоос ч өмнө, Таныг дэлхий ба ертөнцийг төрүүлэхээс ч өмнө, Үүрдээс үүрд мөнх хүртэл Та Бурхан.
- **1 Тимот 1:17** Эрин үеүдийн Хаан, мөхөшгүй, үл үзэгдэх цорын ганц Бурханд хүндлэл ба алдар нь үеийн үед байх болтугай. Амен.
- **Илчлэл 1:8** Байгаа, байсан, мөн хожим ирэх Төгс хүчит Эзэн Бурхан “Альфа ба Омега нь Би байгаа юм” хэмээн айлдаж байна.

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн. 1 Тесалоник 5:18*

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

Өөрсдийн хүүхдүүдийн төлөө — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

Эшлэл(үүд): Исаия 26:4

Библийн эшлэлээр залбирах:

(Хүүхдийн нэр) Эзэнд үүрд итгэгтүн! Учир нь Эзэн Бурхан дотор Мөнхийн хад бий.

Залбирлын тодорхой хүсэлт

Багш/Ажилчид (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та _____-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Танд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- _____ Эзэнд үүрд итгэгтүн! Учир нь Эзэн Бурхан дотор Мөнхийн хад бий. *Исаия 26:4*

Сургуулийн төлөө залбирах – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!